



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АШИГЛАЛТ ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН БАЙДАЛД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: УАГ-БНАТАГ-2018/02-НА



Дүгнэлт: Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс 3322.5 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй, гэрээний дагуу ажлыг гүйцэтгээгүйгээс 629.8 сая төгрөгийн төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдсан байна.

Баянхонгор 2018 он

Тайланг хянасан:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор

Б.Мөнхбат

Аудитын менежер

Д.Цэцэгмаа

Тайланг бэлтгэсэн:

Ахлах аудитор

А.Цээням

Аудитор

Ж.Өсөхбаяр

2018 оны 06 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын

Цахим хуудаснаас үзнэ

үү: www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Аймгийн ЗДТГ-ын байр, Баянхонгор сум, Баянхонгор аймаг-64000 Монгол Улс

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....2

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН.....3

Аудит хийсэн үндэслэл, БҮРЭН ЭРХ.....3

Аудитын зорилт, ХАМАРСАН ХҮРЭЭ.....3

Аудитын АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....3

Ерөнхий зүйл:.....4

Зорилт 1. 2014-2017 онд төсвийн хөрөнгөөр болон хандив, тусламжийн эх үүсвэрээр бэлтгэгдсэн 362.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, 27 байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 3322.5 сая төгрөгийн барилга, байгууламж ашиглалтгүй байна.....5

Аудитын дүн.....5

1.1 Байгууллагууд өөрийн хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламжийн хувийн хэргийг бүрэн хөтөлж баяжилт хийгээгүй байна.....5

1.2 Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт хангалтгүй, ашиглаагүй, барилга байгууламжаас бусдад ашиглуулахдаа аймгийн ИТХ-ын 2009 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.....5

1.2.1 ОНӨ-д бүртгэлтэй барилга байгууламжаас 3322.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий барилга, байгууламж ашиглалтгүй байна.....5

1.2.2. 2017 оны жилийн эцсийн байдлаар 12 байгууллагын 2627.2 сая төгрөгийн хөрөнгө дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байгаа ба гүйцэтгэгч гэрээний дагуу ажлыг гүйцэтгээгүйгээс 629.8 сая төгрөгийн санхүүжилт нь төсвийн үрэгүй зардал болж байна.8

1.2.3 Орон нутгийн өмчийн зарим барилга байгууламжийг бусдад эзэмшүүлж ашиглуулахдаа түрээсийн болон ашиглуулах гэрээ байгуулаагүй, түрээсийн гэрээгээр ашиглуулж байгаа объектийн түрээсийн төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.....9

1.3.1 2014-2017 онд төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр нэмэгдсэн 362.4 сая төгрөгийн барилга байгууламжийг бүртгэлд бүрэн тусгаагүй байна.....11

1.3.2 Орон нутгийн өмчийн хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах үйл ажиллагаа нь хууль тогтоомжтой бүрэн нийцээгүй байна.....12

Зорилт 2. Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг хууль, тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлээгүй байна.....15

2.1. Байгууллагууд нь орон нутгийн өмчийн барилга байгууламжийн тооллогыг зарим байгууллага тооллогыг чанар муутай хийсэн, үр дүнг бүрэн хэлэлцээгүйгээс хөрөнгө дутагдаж байна.....15

2.1.1. Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн тооллогыг хуульд заасан хугацаанд явуулж ажилласан байна.....15

2.1.2. Түүвэрт хамрагдсан байгууллагаас дийлэнх байгууллага нь хуулийн дагуу өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулж ажиллаж байна.....15

2.1.3. Байгууллагуудын тооллогын комисс нь хөрөнгийн тооллогыг чанартай явуулан, үр дүнг хэлэлцээгүйгээс зарим буулгасан болон үрээдсэн хөрөнгүүдийг хөрөнгийн дүнд оруулж тоолсон байна.....16

2.2 Төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууллагын тайланд тусгагдсан барилга байгууламжууд нь төрийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүрэн бүртгэгдсэн ч хөрөнгүүдийг нэр төрлөөр “Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн систем”-д бүрэн оруулаагүй байна.....16

2.2.1. Орон нутгийн өмчийн хөрөнгүүд нь төрийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүрэн бүртгэгдсэн байна.....16

2.2.2. Төрийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн орон нутгийн өмчийн барилга байгууламжийг “Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн систем”-д бүрэн оруулаагүй байна.....17

2.3 Орон нутгийн өмчийн газар нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй байна.....17

2.3.1 ОНӨГ нь 2014-2017 онуудад орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хадгалалт хамгаалалтын байдлыг хянан шалгах, түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.....17

2.3.2. 2016 онд ОНӨ-ийн барилга байгууламжийн нэгдсэн тооллого явуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан байна.....22

АУДИТЫН ДҮГНЭЛТ.....23

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....25

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НА	Нийцлийн аудит
ОНӨ	Орон нутгийн өмч
ОНО	Орон нутгийн орлого
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨББ	Орон нутгийн өмчийн барилга, байгууламж
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАГ	Төрийн аудитын газар
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
УИХ	Улсын их хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол улсын ерөнхий аудиторын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/06 тоот тушаалаар батлагдсан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Орон нутгийн өмчийн хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламжийн 2014-2017 оны хөдлөл, өөрчилөлт, 2017 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд аудит хийж аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх ерөнхий зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн ашиглалт хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх.
- Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Аудитыг Баянхонгор аймгийн ОНӨГ болон барилга байгууламжийг ашиглагч төсвийн байгууллагууд, ОНӨ-т нийт 84 байгууллагын 2014-2017 оны санхүүгийн тайлан тэнцэл, хөрөнгийн данс бүртгэл, хөрөнгийн ашиглалт, судалгаа, мэдээлэл үйл ажиллагааны тайлан холбогдох бусад материалд үндэслэн аймгийн ОНӨГ болон холбогдох байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэнийг хамруулан түүврийн аргаар шалгав.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт, шалгалтын стандарт, нийцлийн аудитын түр журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга, лавлагаа болон судалгаа авч, тайлан баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийн аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын Засаг, Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Газрын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, болон дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам.

Аудит хийсэн хугацаа : Аудитыг 2018 оны 05-р сарын 18-наас эхэлж 06-р сарын 25- ны хооронд хийж гүйцэтгэв.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн : Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер Д.Цэцэгмаа үе шатны ажлын хяналт тавьж, ахлах аудитор А.Цээням, аудитор Ж.Өсөхбаяр нар гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолоор аймгуудын ЗДТГ-ын бүтэц орон тоог шинэчлэн баталсны дагуу аймгийн Засаг даргын 2016 оны А/633 тоот захирамжаар Орон нутгийн өмчийн газрыг 10 орон тоотойгоор байгуулсан ба орон нутгийн өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн-1, орон нутгийн бүртгэл ашиглалт хариуцсан мэргэжилтэн-1, санхүү өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн-1 тус тус ажиллаж байна.

Орон нутгийн өмчид 2014 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар 124580.7 сая төгрөгийн барилга байгууламж бүртгэлтэй байсан бол 2014 оноос хойших өөрчлөлтөөр 65835.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 6586.2 сая төгрөгөөр хасагдаж 183830.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

2014-2017 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 6586.2 сая төгрөгийн барилга байгууламжийг худалдаж, шилжүүлж, акталснаас дуудлага худалдааны орлогоор 611.8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

АУДИТЫН ДҮН

Зорилт 1. 2014-2017 онд төсвийн хөрөнгөөр болон хандив, тусламжийн эх үүсвэрээр бэлтгэгдсэн 362.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, 27 байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 3322.5 сая төгрөгийн барилга, байгууламж ашиглалтгүй байна.

1.1 Байгууллагууд өөрийн хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламжийн хувийн хэргийг бүрэн хөтөлж баяжилт хийгээгүй байна.

Барилгын тухай хуулийн 33.1.18¹-д заасны дагуу Барилга хот байгуулалтын сайдын 2016.11.10-ны өдрийн 180 дугаар тушаалаар "Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам" батлагдсан ч төсөвт болон орон нутгийн өмчит ААН байгууллагууд Барилгын тухай хуулийн 46.1.2²-д заасны дагуу барилга байгууламжийн хувийн хэргийг бүрэн хөтлөөгүй, 46.1.12³ -д заасны дагуу баяжилт хийгээгүй байна.

Аудитаар түүвэрт хамрагдсан 84 байгууллагаас 12 байгууллага өөрийн өмчид бүртгэлтэй барилга байгууламжид хувийн хэрэг нээгээгүй, 18 байгууллага хувийн хэрэгт

Хүснэгт1. Барилга байгууламжийн хувийн хэргийг бүрэн хөтөлж баяжилт хийгээгүй байгууллагын жагсаалт									
№	Сум	Байгууллага	Хувийн хэрэг		№	Сум	Байгууллага	Хувийн хэрэг	
			Нээгээгүй	баяжилт хийж хөтлөөгүй				Нээгээгүй	баяжилт хийж хөтлөөгүй
1	Баянхонгор	АЗДТГ	+	+	10	Шаргалжуут	Цэцэрлэг	+	+
2	Баянлиг	ЗДТГ	+	+	11	Шаргалжуут	ЭМТ	+	+
3	Баянлиг	ЭМТ	+	+	12	Баянхонгор	ХДТеатр	+	+
4	Шинэжинст	ЭМТ		+	13	Баянхонгор	Номгон ЕБС	+	+
5	Баянцагаан	Сургууль	+	+	14	Баянхонгор	Баян-Ойт ЦС	+	+
6	Галууг	ЭМТ		+	15	Баянхонгор	1-р цэцэрлэг	+	+
7	Баян-Овоо	Сургууль		+	16	Баянхонгор	ХХАА-н газар	+	+
8	Эрдэнэцогт	Сургууль		+	17	Баянхонгор	ЗООНОЗӨСТ		+
9	Өлзийт	ЭМТ		+	18	Баянхонгор	Асрамжийн төв	+	+

баяжилт хийж, хөтлөөгүй байгаа тул зөрчлийг арилгуулах зөвлөмжийг сум, байгууллагын дарга нарт хүргүүлэв.

1.2 Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт хангалтгүй, ашиглаагүй, барилга байгууламжаас бусдад ашиглуулахдаа аймгийн ИТХ-ын 2009 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.2.1 ОНӨ-д бүртгэлтэй барилга байгууламжаас 3322.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий барилга, байгууламж ашиглалтгүй байна.

1.2.1.1 Аймгийн ОНӨГ нь 2017 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 262 байгууллагын 183693,3 сая төгрөгийн барилга байгууламжийн дүнг нэгтгэснийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн байна.

¹ барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмыг батлах;

² энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх;

³ барилгын ашиглалтын хугацаанд барилга байгууламжийн баримт бичгийг баяжуулж, хадгалах;

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх актлах журам”-ын 1.3⁴-д заасны дагуу орон нутгийн өмчийг төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудад эзэмшүүлэх гэрээг 2015 оноос 2 жилийн хугацаагаар байгуулсан ба түүнээс хойш тус гэрээг дахин шинэчлэн байгуулаагүй байгаа тул гэрээг шинэчлэн байгуулах зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүлэв.

1.2.1.2. Төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудын өөрийн хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламжуудын газрын гэрчилгээг түүвэрлэн шалгахад Баянцагаан сумын ИТХ, Бууцагаан сумын Баянбүрдний бага сургууль, Эрдэнэцогт сумын Цэцэрлэг, Шаргалжуут тосгоны ЭМТ-ийн барилга байгууламжууд мөн сумдад шинээр баригдсан багийн төвүүдийн газрын гэрчилгээг аваагүй, дийлэнх байгууллагууд газрын гэрчилгээ улсын бүртгэлд бүртгүүлээгүй зөрчил илэрч зөрчлийг арилгах зөвлөмжийг сум, байгууллагын дарга нарт хүргүүлэв.

1.2.1.3. Орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн ашиглалтыг шалгахад УТХО-р хийгдсэн зарим тоног төхөөрөмж, сумдын ЗДТГ-уудын орон сууцнууд ашиглалтгүй, байгууллагуудын өөрийн эзэмшлийн барилга байгууламж байхад түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байсан зэрэг зөрчил илэрлээ. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Бууцагаан, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдын ЗДТГ-уудын хөрөнгөнд бүртгэлтэй орон сууцны барилгуудад хүн амьдрахгүйгээс хөрөнгийн чанар муудаж ашиглалтгүй байна.

- УТХО-аар 2014 онд 197.7 сая төгрөгийн 5тн мах хадгалах хөргүүр, бусад тоног төхөөрөмж бүхий нядалгааны цехийг Бууцагаан сумын ЗДТГ-ын дэргэдэх агуулахын барилга /уг барилга 2016 онд хувьчлагдсан/ дотор суурилуулсан байна.

Тус хөрөнгө нь аймгийн ХХААГ-т бүртгэлтэй ба нягтлан бодогч өөрийн хөрөнгөнд нядалгааны цехийн барилга 60 жил ашиглана гэж буруу бүртгэсэн, Бууцагаан сумын ЗДТГ-ын няравт хөрөнгийг нэг бүрчлэн картаар хүлээлгэж өгөөгүй, ашиглалтгүй байна. Иймд дээрх хөрөнгийн асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж хэрэгцээтэй газар нь шилжүүлэн ашиглалтыг сайжруулах зөвлөмжийг ХХААГ-ын даргад хүргүүлэв.

- Эрдэнэцогт сумын эргэлтийн эмийн сан нь өөрийн байртай атлаа хувийн орон сууцны өрөө түрээслэн үйл ажиллагаагаа явуулж байна.

⁴ “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ нь Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эзэмшиг, ашиглах, үр өгөөжийг нь дээшлүүлэх, бүрэн бүтэн байдлыг хангах талаар тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээж аймгийн ИТХ-ын Өмчийн албатай байгуулсан “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний дагуу зохицуулна”



Нядалгааны цехийн хөргүүр тоног төхөөрөмж

Эрдэнэцогт сумын Эмийн сангийн барилга

Аудитаар хөрөнгийн ашиглалтын байдлыг газар дээр нь шалгахад түүвэрт хамрагдсан байгууллагуудаас 27 байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй 3322.5 сая төгрөгийн барилга байгууламж ашиглалтгүй байгаа тул цаашид хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаарх санал, зөвлөмжийг сум, байгууллагын дарга нарт хүргүүлэв. /Хавсралт 1/

1.2.1.4. Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 148 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Төрийн улс төрийн болон төрийн тусгай албыг тодорхой хугацаагаар хашихаар томилогдсон төрийн мэдлийн орон сууцанд суух албан тушаалтнуудын жагсаалт”-ыг баталсны дагуу аймгийн ЗДТГ-ын хөрөнгөнд 154.1 сая төгрөгийн 6 орон сууц бүртгэлтэй байна.

Дээрх хөрөнгөөс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2015 оны 77 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын албан тушаалын 29.4 сая төгрөгийн 3 өрөө орон сууцыг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид балансаас балансад 35.0 сая төгрөгөөр шилжүүлсэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны 23 дугаар тогтоолоор аймгийн Цагдаагийн газрын даргын албан тушаалын 23.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий 2 өрөө орон сууцыг 12.4 сая, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2014 оны 146 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын даргын албан тушаалын 29.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий 3 өрөө орон сууцыг 23.8 сая төгрөгөөр тус тус худалдсан байна.

Харин аймгийн Цэргийн штабын даргын албан тушаалын орон сууцыг 2016 онд 56.0 сая, 2017 онд аймгийн Засаг даргын албан тушаалын байрыг 52.0 сая, Цагдаагийн газрын дарга, Шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалын орон сууц байсаар байхад дахин 52.0 сая төгрөгөөр 2 орон сууц нийт 212.0 сая төгрөгийн албан тушаалын орон сууцыг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Дээрх худалдан авсан Засаг даргын албан тушаалын орон сууцанд аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, хуучин Шүүхийн ерөнхий шүүгчийн албан

тушаалын орон сууцанд ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн албаны ажилтан амьдарч байна.

Энэ нь тухайн албан тушаалын орон сууцнуудыг дуудлага худалдаагаар худалдсан, бусад байгууллагад шилжүүлсэн, зарим албан тушаалын орон сууцнууд байсаар байхад дахин орон сууц худалдан авах төсөв баталж төсвийн үргүй зардал гарах эрсдэлийг бий болгож байгаа тул аймгийн Цагдаагийн газрын дэд дарга, ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн албаны ажилтан нарын амьдарч байгаа орон сууцнууд нь Засгийн газрын 1998 оны 148 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан албан тушаалтны жагсаалтад ороогүй тул холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад, цаашид дээрх тогтоолыг хэрэгжүүлэн төрийн мэдлийн орон сууцыг худалдан авах шийдвэр гаргуулахдаа хуучин орон сууцыг худалдах асуудлыг хамтад нь шийдвэрлүүлж төсвийн үргүй зардал гаргахгүй байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргад хүргүүлэв.

1.2.2. 2017 оны жилийн эцсийн байдлаар 12 байгууллагын 2627.2 сая төгрөгийн хөрөнгө дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байгаа ба гүйцэтгэгч гэрээний дагуу ажлыг гүйцэтгээгүйгээс 629.8 сая төгрөгийн санхүүжилт нь төсвийн үргүй зардал болж байна.

Аудитын илрүүлэлт:

- *Өлзийт сумын ЗДТГ-ын дуусаагүй барилгад 10.0 сая төгрөгөөр бүртгэлтэй 3-р багийн төвийн хурлын заалыг 37.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр бариулахаар 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдөр “ЗЭББ” ХХК-тай гэрээ байгуулан 2014 оны 12 дугаар сарын 24-нд ОНХС-с 10.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.*

Гүйцэтгэгч “ЗЭББ” ХХК нь багийн төвийн барилгыг бариагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байгаа нь 2014.12.24-ий өдөр “ЗЭББ” ХХК-тай байгуулсан гэрээний 1.1-д “гүйцэтгэгч нь ... барилгын ажлыг 2015 оны 08 дугаар сард барьж хугацаанд нь захиалагчид хүлээлгэн өгнө” гэсэн заатыг зөрчсөн тул төсвөөс олгосон санхүүжилтийг буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

- *Өлзийт сумын төвд сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр тоглоомын талбай бариулахаар “Халзан хайрхан” ХХК-тай 2012 оны 08 дугаар сарын 27-ны өдөр 7.4 сая төгрөгийн гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон. Гүйцэтгэгчийн барьсан тоглоомын талбай стандартад нийцэхгүй тул буцаасан гэх шалтгаанаар тус ажил хийгдээгүй, гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй ч Өлзийт сумын ЗДТГ-ын дуусаагүй барилгад 7.4 сая төгрөгөөр бүртгэсэн байна. Иймд гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлж хөрөнгийг хүлээн авах хугацаатай албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлэв.*

- *Баянговь сумын төвд 39.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Халуун ус, зочид буудал”-ын барилга барих ажлын гүйцэтгэгчээр 2008 онд “Дорнын гэгээ” ХХК шалгарч ажлыг гүйцэтгэсэн боловч барилга угсралтын ажлыг дуусгаагүй, барилгын суурь, ханын өрлөгийн ажлыг хийгээд орхисон байна. Энэ хөрөнгө нь сумын ЗДТГ-ын дуусаагүй барилгад 33.0 сая төгрөгөөр бүртгэлтэй байгаа ба дуусаагүй барилга болон материалыг дуудлага худалдаагаар худалдан борлуулах хүсэлтээ ОНӨГ-т сумын Засаг даргын 2017.06.05-ы өдрийн 56 тоот албан бичгээр хүргүүлсэн байна*

Дээрх барилгыг барихад шаардлагатай зарим материалыг тухайн үед сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн гэсэн тайлбарыг сумын ЗДТГ-ын 2018.06.14-ы 78 тоот албан бичгээр ирүүлсэн боловч тайланд материалыг нэр төрлөөр тусгаагүй, аудитаар барилгын ажлын гүйцэтгэл, материалын тооцоог хийхэд шаардлагатай баримт материал нь байхгүй байгаа тул

холбогдох хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулахаар албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлэв.

- Эрчим хүчний яамнаас 2014 онд зарласан 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Баянцагаан сумын төвд халаалтын зуухны газар, дулааны шугам сүлжээ барих ажил”-ын гүйцэтгэгчээр “Унаган сувраа” ХХК шалгарч Эрчим хүчний яам, Баянхонгор аймгийн ЗДТГ-тай Эрчим хүчний сайдын багцаас 150.0 сая, Баянцагаан сумын ОНХС-с 150.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр 2014 оны 07 дугаар сарын 02-нд гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн байна. Баянцагаан сумын ОНХС-с зураг төсвийн үнэнд “Түмэд эрүүл” ХХК-д 17.4 сая, гүйцэтгэгчид 45.0 сая төгрөгийн урьдчилгаа нийт 62.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон ч ЗДТГ-ын дуусаагүй барилгад 150.0 сая төгрөгөөр орлого авч бүртгэснийг санхүүгийн тайланд олгосон санхүүжилтийн дүнгээр залруулж бүртгэх албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлэв.

Гүйцэтгэгч “Унаган сувраа” ХХК нь урьдчилгаа 45.0 сая төгрөгт халаалтын зуухны барилгын ажлын зөвхөн 17,8х7,8 хэмжээтэй суурийн ажлыг хийгээд нэмэлт санхүүжилт олгоогүйгээс барилга угсралтын ажил зогссон, тус суманд “Бест хонгор” ХХК өөрийн хөрөнгөөр төвлөрсөн халаалтын зуух барьж халаалтанд оруулсан байгаа тул дээрх ажилд зарцуулсан 62.4 сая төгрөгийн санхүүжилт нь төсвийн үргүй зардал болж хувирсан байна. Иймд тус компаний гүйцэтгэсэн ажлыг үнэлж олгосон урьдчилгааны тооцоог холбогдох байгууллагаар шалгуулах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлэв.

- Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар нь “Насан туршийн боловсролын төв”-ийн барилга барихаар Баянхонгор сумын 5-р багийн нутаг дэвсгэрт газар авч инженер, геологийн дүгнэлт гаргуулах зардалд 1.2 сая төгрөг зарцуулж зардлыг дуусаагүй барилгаар бүртгэсэн, аймгийн Түүх угсаатны зүйн музей нь 3.2 сая төгрөгөөр музейн барилгын зураг төсөв хийлгэж дуусаагүй барилгад бүртгэсэн ба барилгын хөрөнгийн үүсвэр батлагдаагүйгээс үргүй зардал болсныг хөрөнгөөс хасч залруулах албан шаардлагыг ОНӨГ-т хүргүүлэв.

- Жаргалант сумын ЗДТГ-ын дуусаагүй барилгад бүртгэлтэй өвс тэжээлийн агуулахын барилгыг 2014 оноос 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр барьж байгаа ба сумын ОНХС-с 19.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон ч гүйцэтгэгч барилгыг дуусаагүйгээс захиалагч сумын ЗДТГ асуудлыг Шүүхэд шилжүүлсэн байна.

- Бууцагаан сумын төвд Соёлын төвийн барилгыг “Оорцог уул” ХХК улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 205.0 сая төгрөгийн санхүүжилт авч суурийн ажлыг 2010 онд хийснийг, Бага сургуулийн барилгыг “Бүтээлч шинэ сонголт” ХХК төсвийн хөрөнгө оруулалтаар 301.8 сая төгрөгийн санхүүжилт авч барилгын суурь 2 давхарын карказын ажлыг хийснийг тус тус дуусаагүй барилгад бүртгэсэн байна. Тус суманд “Шинэ сум” төсөл хэрэгжсэнээр дээрх барилга байгууламжийн ажил зогссон төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсан байна. Цаашид барилгыг хэрхэн ашиглах саналыг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн аймгийн ИТХ-д асуудлыг оруулж шийдвэрлүүлэх зөвлөмжийг сумын Засаг даргад хүргүүлэв.

- Баян-Овоо сумын ЗДТГ-ын дуусаагүй барилгад 5.8 сая төгрөгөөр бүртгэлтэй спорт заалны зориулалт бүхий барилга нь 1990 онд баригдаж эхэлсэн ба барилгын суурь, ханын өрлөг хийгдсэн. Аймгийн МХГ-с тус барилгыг олон жил болсон цаашид ашиглах боломжгүй гэсэн тул тухайн хөрөнгийн асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг Баян-Овоо сумын Засаг даргад хүргүүлэв.

1.2.3 Орон нутгийн өмчийн зарим барилга байгууламжийг бусдад эзэмшүүлж ашиглуулахдаа түрээсийн болон ашиглуулах гэрээ байгуулаагүй, түрээсийн гэрээгээр ашиглуулж байгаа объектийн түрээсийн төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Байгууллагууд нь орон нутгийн өмчийн барилга байгууламжийг гэрээгээр бусдад ашиглуулахдаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 19 дүгээр тогтоолоор “Орон нутгийн өмчийн барилга байгууламж болон үндсэн хөрөнгийг

түрээсээр эзэмшүүлэх журам”-ын дагуу гэрээ байгуулж түрээсийн төлбөрийг төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Түүвэрт хамрагдсан байгууллагуудаас өөрийн эзэмшлийн барилга байгууламжийг 10 байгууллага түрээсийн гэрээ байгуулаагүй бусдад ашиглуулсан, 6 байгууллага түрээсийн төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт 3. Түрээсийн гэрээ байгуулаагүй бусдад эзэмшүүлж ашиглуулж байгаа барилга, байгууламжийн жагсаалт

Сум	Байгууллага	Объектийн нэр
БАЯНЛИГ	Сургууль	Хуучин хичээлийн байр
БАЯНЛИГ	ЭМТ	орон сууц
БАЯНЦАГААН	ЗДТГ	Халуун усны барилга
ЖАРГАЛАНТ	ЗДТГ	10 айлын орон сууц
ГАЛУУТ	ЭМТ	2 айлын орон сууц
БАЯН-ОВОО	ЗДТГ	Хуучин гуанзны барилга
ЭРДЭНЭЦОГТ	ЭМТ	Аж ахуйн хэсгийн барилга
ӨЛЗИЙТ	Сургууль	Хуучин дотуур байр
ШАРГАЛЖУУТ	Цэцэрлэг	Хуучин цэцэрлэгийн барилгын хүүхэд харах үйлчилгээ явуулж буй хэсэг
ШИНЭЖИНСТ	ЗДТГ	Халуун усны барилга

Хүснэгт4. Түрээсийн төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй байгууллагын жагсаалт

Сум	Байгууллага	Объектийн нэр
БАЯНЛИГ	ЭМТ	Эхийн амрах байр, Орон сууц
ЭРДЭНЭЦОГТ	ЗДТГ	Жи Мобайлын станц
ӨЛЗИЙТ	ЗДТГ	Уурын зуух
ӨЛЗИЙТ	Сургууль	Дотуур
ШАРГАЛЖУУТ	Цэцэрлэг	Хуучин цэцэрлэг
БАЯНХОНГОР	1-р 10 жил	цайны газар

Аудитын илрүүлэлт:

- Баянлиг сумын ЭМТ-ийн хөрөнгөнд бүртгэлтэй Эхийн амрах байр, орон сууц ашиглалтгүй байгаа ба тэдгээр барилгад оёдолчин, иргэдийг түрээсээр түр оруулсан боловч гэрээ хийгээгүй, орлогын 0.3 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй тул төлбөрийн акт тогтоов.

- Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багийн цэцэрлэгийн хуучин барилгыг ХААН, Төрийн банк болон Хүүхэд харах үйлчилгээнд түрээслүүлж байгаа ба банкуудтай түрээсийн гэрээ байгуулан төлбөрийн 3.1 сая төгрөгийг Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9.2⁵ дэх хэсэгт заасныг зөрчсөн тул сумын ОНХО-ын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож аудитын явцад барагдуулав.

Мөн Хүүхэд харах үйлчилгээ явуулж буй иргэнтэй түрээсийн гэрээ байгуулаагүй тул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2009 оны 19-р тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн барилга, байгууламж болон үндсэн хөрөнгийн түрээсээр эзэмшүүлэх журам”-ын дагуу түрээсийн гэрээ байгуулж төлбөрийг ашиглаж эхэлсэн хугацаанаас нөхөн тооцож авах зөвлөмжийг сумын Засаг даргад хүргүүлэв.

- Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын хуучин конторын барилгыг иргэн, ААН-үүдэд түрээсээр ашиглуулж байгаа боловч 2017 онд түрээсийн төлбөр 6 иргэнээс 1.0 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн тул төлбөрийн акт тогтоож аудитын хугацаанд барагдуулав.

- Эрдэнэцогт сумын ЭМТ-ийн хөрөнгөнд бүртгэлтэй Аж ахуйн хэсгийн складын барилгыг сумд ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААН-үүдэд ашиглуулж байгаа боловч түрээсийн гэрээ байгуулж төлбөр аваагүй, тухайн барилгын халаалтын зардлыг ЭМТ-өөс төлсөн зөрчил илэрч цаашид төсвөөс төлөхгүй байх зөвлөмжийг ЭМТ-ийн даргад хүргүүлэв.

- Баян-Овоо сумын ИТХ-ын үндсэн хөрөнгөнд банзыг бүртгэсэн байгаа ба тус банзнаас хашаа хийж гэрээгээр худалдсан 4.5 сая төгрөгийг тайланд авлагаар тусгаагүй, иргэдэд худалдсан банзны үнэ 0.9 сая төгрөгийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй нь Нягтлан бодох

⁵ Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд “Сумын төсвийн татварын бус орлого нь” 23.9.2 дахь хэсэгт “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого”-оос бүрдэнэ”

бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2⁶ дэх хэсэгт заасныг зөрчсөн тул холбогдох хүмүүсээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Эрдэнэцогт, Бууцагаан сумын ЭМТ-ийн ашиглалтгүй барилгыг сумдын ЗДТГ нь өөрийн эзэмшилд шилжээгүй байхад улсын төсөв болон ОНХС-ийн хөрөнгөөр засвар хийж ахуйн үйлчилгээний зориулалтаар бусдад ашиглуулах шийдвэр гаргасан, Шаргалжуут тосгоны цэцэрлэгийн барилгыг Баянхонгор сумын Засаг дарга гэрээ байгуулан түрээсэлсэн байна.

Хүснэгт5. ЗДТГ гэрээ хийн бусдад ашиглуулж байгаа барилга байгууламж

Сум	Байгуулаг	Ашиглаж буй зориулалт	Балансын үнэ	Цаашид авах арга хэмжээний санал
Эрдэнэцогт	ЭМТ	Аж ахуйн хэсгийн Складын барилга /ОНХС-ийн хөрөнгөөр засвар хийж сумын АҮ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНБ-д ашиглуулж байна	142.5	Сумын ЗДТГ-т балансаас балансад шилжүүлэх
Бууцагаан	ЭМТ	1969 онд ашиглалтад орсон хуучин эмнэлгийн барилгад улсын төсвийн хөрөнгөөр 20.0 сая төгрөгийн засвар хийж “Өлзийт нөмөрт” хоршоонд үйл ажиллагааны зардлаа дааж АҮ-ий зориулалтаар гэрээ байгуулан ашиглуулж байна.	267.7	Сумын ЗДТГ-т балансаас балансад шилжүүлэх болон дуудлага худалдаагаар худалдах талаар судлах.
Шаргалжуут	Цэцэрлэг	Цэцэрлэгийн хуучин барилгад тосгоны багийн төв, ХААН, Төрийн банк болон Хүүхэд харах үйлчилгээ үйл ажиллагаа явуулж байна	178.6	Баянхонгор сумын 8-р багийн хөрөнгөнд балансаас балансад шилжүүлэх
НИЙТ			588.8	

Цаашид хөрөнгийг өөрийн эзэмшилд шилжүүлэх саналаа аймгийн ОНӨГ хүргүүлэн шийдвэр гаргуулан, аймгийн ИТХ-ын 2009 оны 19-р тогтоолоор батлагдсан журмыг мөрдөж, төсвөөс урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байх зөвлөмжийг холбогдох байгууллагын удирдлагуудад хүргүүлэв.

1.3 Орон нутгийн өмчийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлага худалдаагаар худалдах, актлахдаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор баталсан журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.3.1 2014-2017 онд төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр нэмэгдсэн 362.4 сая төгрөгийн барилга байгууламжийг бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

1.3.1.1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх актлах журам”-ыг хэрэгжүүлээгүйгээс байгууллагууд төсвийн хөрөнгө оруулалтаар болон хандив тусламжаар бий болсон хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2. дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлагыг холбогдох байгууллагын дарга нар хүргүүлэв.

⁶ “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ЗДТГ-ын өргөтгөлийн барилгад 2017 онд хийсэн 125.0 сая төгрөгийн их засварын ажил, Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн гаднах 13.9 сая төгрөгийн үнэ бүхий зам, талбайг тус тус аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 64 дүгээр тогтоолоор орлого авах тухай шийдвэр гарсан ч орлого аваагүй.
- Баянлиг сумын ЗДТГ-т аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 79 дүгээр тогтоолоор 13.5 сая төгрөгийн үнэ бүхий 1 өрөө байр орлого авах шийдвэр гарсан ч үндсэн хөрөнгөнд бүртгээгүй.
- Баян-Овоо суманд ААН-үүдийн хөрөнгө оруулалтаар 2015 онд 100.0 сая төгрөгөөр барьж өгсөн 2 багийн төвийн барилгыг үндсэн хөрөнгөнд орлого аваагүй.
- Галуут сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөс 110.0 сая төгрөг зарцуулан барьж буй нийтийн ахуйн үйлчилгээний барилгыг дуусаагүй барилга дансанд олгосон санхүүжилтийн хэмжээгээр бүртгээгүй.

1.3.1.2. Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг шалгахад төсөвт 14 байгууллага урсгал засвар, шинэчлэлийн 64.6 сая төгрөгийн хөрөнгийг барилга, байгууламжийн дансанд бүртгэсэн байгаа тул данснаас хасаж зөрчлийг арилгах, 2824.4 сая төгрөгийн барилга байгууламжийг 21 байгууллага бусад үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлагыг ОНӨГ-т хүргүүлэв. /Хавсралт 2,3/

1.3.2 Орон нутгийн өмчийн хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах үйл ажиллагаа нь хууль тогтоомжтой бүрэн нийцээгүй байна.

1.3.2.1.ТБОНӨ-ийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1⁷-т заасны дагуу хөрөнгийг худалдаж шилжүүлж, акт тогтоон устгахдаа хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1⁸-т заасны дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гарган аймгийн ОНӨГ-т хүргүүлэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын шийдвэр гаргуулан хөрөнгийг данснаас хасаж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Харин дуудлага худалдаагаар зарагдсан хөрөнгийн 13,8 сая төгрөгийн орлогыг аймгийн орон нутгийн орлогод дутуу төвлөрүүлсэн, байгууллагын нягтлан бодогч нар ИТХ-ын шийдвэр гарсан 121.6 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаагүй, хуучин барилга байгууламжийг буулган материалыг ашиглан шинэ барилга, байгууламж барьсан байхад 483.2 сая төгрөгийн хөрөнгийг актлах шийдвэр гаргуулж бүртгэлээс хасаагүй, “Баянхонгор-Чандмань” ХХК нь байгууллагын хөрөнгийн бүртгэлд тусдаа бүртгэлтэй “Контторын барилга”, “Хурлын

⁷ 31.1-т "... ашиглах хугацаа нь дууссан эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон... эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.1-т худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар

⁸ 31.3.1-т худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх;

заал"-ыг буулгаж шинэ барилга барихдаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар зөвхөн конторын барилгыг актлах шийдвэр гаргуулж, 9.7 сая төгрөгөөр бүртгэлтэй "Хурлын заал"-ыг актлах шийдвэрийг гаргуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Дуудлага худалдааны орлогыг бүрэн төвлөрүүлээгүй.

- Эрдэнэцогт сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 196.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий 2014 онд ашиглалтад орсон дулааны шугам сүлжээг аймгийн ИТХ-ын 2017.06.02-ны өдрийн хуралдааны 6/4 тоот тогтоолоор хөрөнгийн зориулалтыг өөрчлөхгүйгээр төсөл сонгон шалгаруулах аргаар хувьчилж, хувьчлалаас орсон орлогыг Эрдэнэцогт сумын Орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэхээр шийдвэрлэсний дагуу "Маралгүн" ХХК 350.0 сая төгрөгөөр худалдан авч 2017.10.26-нд 87.5 сая төгрөгийг дэнчингийн төлбөрт, үлдэгдэл 262.5 сая төгрөгийг 2018.01.03-нд төлжээ.

Эрдэнэцогт сумын ИТХ-ын 2018.02.22-ны өдрийн хуралдааны 5/02 тоот тогтоолоор тус орлогыг сумын ОНХС-д хуваарилж, хатуу хучилттай автозам барих төсөл, арга хэмжээнд зарцуулахаар тодотгон баталсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.12⁹, 34 дүгээр зүйлийн 34.2.1¹⁰ дахь заалтыг тус тус зөрчсөн, мөн дээрх орлогыг сумын ОНХС-д хуваарилахаар шийдвэр гаргасан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2¹¹ дахь заалттай нийцэхгүй байгаа тул тус орлогыг аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

- Баянхонгор аймгийн ИТХ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 1979 онд ашиглалтад орсон Баянхонгор сумын 1 дүгээр багийн 12 дугаар байрны 30 тоотын 3 өрөө орон сууцыг Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 146-р тогтоолоор тухайн үеийн аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Юндэнбазарт 23.8 сая төгрөгөөр худалдсан байна. Иргэн Д.Юндэнбазар нь 2017.05.17-нд 10.0 сая төгрөг төлж үлдсэн 13.8 сая төгрөгийг орон сууцны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ өмнөх өмчлөгчөөс аймгийн ИТХ-д шилжээгүй байснаас төлбөрөө төлөөгүй, урсгал засвар 3,0 сая төгрөгөөр хийсэн ба үлдэгдэл 10,8 сая төгрөгийг төлөөгүй байгаа нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1¹² дахь заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

- Аймгийн ХДТ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 19.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий орон сууцыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 11/46 тогтоолоор худалдах шийдвэр гарсны дагуу иргэн Ц.Алтанцэцэгт 19.0 сая төгрөгөөр худалдсан ч иргэн үлдэгдэл 3.0 сая төгрөгийг төлөөгүй байгаа нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5¹³ дахь заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоож аудитын явцад барагдуулав.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гарсан ч данснаас хасагдаагүй хөрөнгө.

- Өлзийт сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 4.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий "Шар хуудасны модон гүүр" нь Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багийн хөрөнгөнд давхар бүртгэлтэй байгаа ба аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 110 дугаар тогтоолоор Өлзийт сумын ЗДТГ-ын хөрөнгөөс хасч Баянхонгор суманд бүртгэх шийдвэр гарсан ч бүртгэлээс хасаагүй байгаа тул хөрөнгөөс хасах албан шаардлагыг ЗДТГ-т хүргүүлэв.

- Галуут сумын иргэн Баатарсүрэнгийн хувийн өмч болох Ахуйн үйлчилгээний барилгад ТА-II төслийн санхүүжилтээр 21.2 сая төгрөгийн засвар хийж ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэсэн ба аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2013 оны 12 сарын сарын 24-ний 167 тоот тогтоолоор актлах шийдвэр гарсан ч данснаас хасаагүй байна. Энэ талаар холбогдох ажилтнуудаас тайлбар авахад тухайн үед иргэнээс тус барилгыг ЗДТГ нь 4.0 сая төгрөгөөр худалдаж аваад 2.0 сая төгрөгийг төлөөгүйгээс иргэн хөрөнгөө шилжүүлж өгөөгүй гэсэн

⁹ "Энэ хуулийн 23 дугаар зүйлд заасныг үл харгалзан өмч хувьчлалын орлогыг төсвийн орлого хэсэгт бүртгэхгүй төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр талд бүртгэнэ",

¹⁰ 34.2.1-д "дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон",

¹¹ "Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ"

¹² "Хувьчилсан эд хөрөнгийн үнийг хувьчилж авсан этгээд өөрийн болон хууль ёсоор авсан дотоод, гадаадын зээлийн мөнгөн хөрөнгөөр / үнэт цаасаар/ төлнө"

¹³ "Худалдан авагч нь дуудлагын худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө."

тайлбар өгсөн тул тус асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх албан шаардлагыг сумын ЗДТГ-т хүргүүлэв.

- Баянхонгор Асрамжийн газрын хөрөнгөнд бүртгэлтэй 96.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий “Ахмад настны цогцолборын барилга”-ыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2016 оны 18 дугаар тогтоолоор хувьчлах шийдвэр гарсны дагуу дуудлага худалдаа зохион байгуулж иргэн Ж.Идэрчулуунд 22.2 сая төгрөгөөр худалдсан боловч хөрөнгөөс хасаагүй байна. Энэ нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2017.05.31-91 тоот тогтоолоор дээрх шийдвэрээ хүчингүй болгосноос иргэн Шүүхэд гомдол гарган уг асуудал шүүхийн шатанд байна.

Буулгасан барилга байгууламж:

- Галуут сумын ЕБС-ийн хөрөнгөнд бүртгэлтэй 1989 онд ашиглалтад орсон 472,5 сая төгрөгийн өртөг бүхий хичээлийн байрыг буулгаж шинэ сургууль барихад материалыг ашигласан ч хөрөнгийг бүртгэлээс хасаагүй тул холбогдох газарт асуудлыг тавьж шийдвэр гаргуулах албан шаардлагыг сумын ЕБС-ийн захиралд хүргүүлэв.

- Галуут сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 1993 онд ашиглалтад орсон 10.7 сая төгрөгийн балансын үнэ бүхий колонкын барилгыг буулган шилжүүлж тухайн үед НИК-ХХК колонкийн барилгыг шинээр барьж өөрийн хөрөнгөндөө бүртгэсэн байхад ЗДТГ-ын хөрөнгөөс хасаагүй тул холбогдох газарт асуудлыг тавьж шийдвэр гаргуулах албан шаардлагыг сумын ЗДТГ-ын даргад хүргүүлэв.

1.3.2.2. Дуудлага худалдаагаар зарагдсан хөрөнгийн 41.5 сая төгрөгийн орлогыг хугацаанд нь төвлөрүүлээгүй, үнийн төлбөрт 3 орон сууц авч хууль зөрчсөн байна.

- Баянлиг сумын ЕБС-ийн 1987 онд ашиглалтад орсон 1623 м² талбайтай 3 давхар 142.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий дотуур байрны худалдах доод үнийг хөрөнгийн үнэлгээний компаниар 79.2 сая төгрөгөөр тогтоолгож зарагдаагүйгээс Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор баталсан журам болон, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны 10 дугаар тогтоолоор доод үнийг 2 удаа 20 хувиар бууруулан 50.7 сая төгрөгөөр доод үнийг тогтоож дуудлага худалдаа явуулсан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10-р тогтоолын дагуу дуудлага худалдаагаар иргэн Ж.Өлзиймөнхөд 51.7 сая төгрөгөөр зарсан байна. Ж.Өлзиймөнх нь дэнчинд 10.2 сая төгрөг төлж үлдсэн 41.5 сая төгрөгийг 2016.10.31-ны дотор төлөхөөр Үл хөдлөх хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах 2016.03.15-04/2016 тоот гэрээг хийсэн боловч мөнгөө төлөөгүй байна. Энэ талаар Ж.Өлзиймөнхтэй холбогдон утсаар ярихад би дэнчингийн мөнгөө төлсөн, гэрээ байгуулан үлдэгдэл мөнгөө төлөхөөр тохирсон боловч төлж чадаагүй, аймгийн холбогдох удирдлагуудад санал тавьж шийдвэрийг тухай бүр гаргуулсан, би Улаанбаатар хотод байна одоогоор очиж уулзах боломжгүй байна гэсэн тайлбар өгсөн.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2016 оны 79 тоот тогтоолоор барилгын үлдэгдэл үнэ 41.5 сая төгрөгт багтааж 1м²-ын үнийг 600.0 мянган төгрөгөөр тооцож Баянлиг сумын ЗДТГ, Ерөнхий боловсролын сургууль, ЭМТ-д тус бүр 22.5 м² нэг өрөө байр авч хөрөнгөнд бүртгэх шийдвэр гарсан нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1¹⁴, 63.3¹⁵ дахь заалтыг зөрчсөн тул цаашид ТБОНӨ-ийн тухай хуулийг мөрдөж шийдвэр гаргаж байхыг зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Баянлиг сумын ЕБС-ийн дотуур байрны 3 давхар барилгын худалдах доод үнийг 79.2 сая, мөн сургуулийн 1988 онд ашиглалтад орсон багш нарын 4 айлын орон сууцыг 20.1 сая төгрөгөөр тогтоосныг харьцуулахад цаашид хөрөнгийн үнэлгээний компаний тогтоосон үнэлгээг аймгийн ИТХ-ын дэргэдэх үнэлгээний комиссоор хэлэлцүүлж хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

¹⁴ "Хувьчилсан эд хөрөнгийн үнийг хувьчилж авсан этгээд өөрийн болон хууль ёсоор авсан дотоод, гадаадын зээлийн мөнгөн хөрөнгөөр / үнэт цаасаар/ төлнө",

¹⁵ "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад хөрөнгийн эх үүсвэрийг хувьчилж байгаа эд хөрөнгийг худалдан авахад төлбөрийн хэрэгсэл болгохыг хориглоно"



Зорилт 2. Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг хууль, тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлээгүй байна.

2.1. Байгууллагууд нь орон нутгийн өмчийн барилга байгууламжийн тооллогыг зарим байгууллага тооллогыг чанар муутай хийсэн, үр дүнг бүрэн хэлэлцээгүйгээс хөрөнгө дутагдаж байна.

2.1.1. Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн тооллогыг хуульд заасан хугацаанд явуулж ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.1¹⁶-д заасны дагуу байгууллагууд нь барилга байгууламжийн тооллогыг хийсэн байна.

Төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагын удирдлагууд тооллогын комиссыг томилохдоо эд хариуцагч, нягтлан бодогч нарыг тооллогын комиссын дарга, гишүүнээр оруулж томилж байгаа нь хөрөнгө тооллого чанаргүй хяналт сул явагдах эрсдэл үүссэн байна. Тухайлбал, Шинэжинст, Бууцагаан сумын ЕБС, Галуут, Өлзийт сумын ЭМТ, Баянхонгор сумын 4-р цэцэрлэг нь тооллогын комиссыг томилохдоо хөрөнгийг хариуцаж тооллого хийлгэх нярав, түүний үр дүнг тооцож бүртгэл хөтлөх нягтлан бодогч нарыг оруулсан. Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхыг тухай бүр нь аудитын явцад зөвлөж ажиллаа.

2.1.2. Түүвэрт хамрагдсан байгууллагаас дийлэнх байгууллага нь хуулийн дагуу өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулж ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4¹⁷-т заасны дагуу түүвэрт хамрагдсан төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагууд өмч хамгаалах байнгын зөвлөлийг 16 байгууллага байгуулаагүй, мөн зарим байгууллага өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийг албан тушаалаар бус нэр зааж томилсноос дарга, гишүүд нь ажлаас чөлөөлөгдсөн байхад зөвлөлийг шинэчлэн байгуулаагүй байсан зөрчил илэрснийг арилгах зөвлөмжийг ОНӨГ-т хүргүүлэв.

¹⁶ ТБОНӨ-ийн тухай хуулийн 70.1-т 1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/

¹⁷ ТБОНӨТХ-ийн 31.4 "...өмч хамгаалах Байнгын зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, эсхүл түүний үүрэг биелүүлдэг менежерээр толгойлуулж ерөнхий ня-бо, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр захирлын шийдвэрээр байгуулна.

2.1.3. Байгууллагуудын тооллогын комисс нь хөрөнгийн тооллогыг чанартай явуулан, үр дүнг хэлэлцээгүйгээс зарим буулгасан болон үрэгдсэн хөрөнгүүдийг хөрөнгийн дүнд оруулж тоолсон байна.

2009 онд хийсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр Шинэжинст сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 1986 онд ашиглалтад орсон 500 төгрөгийн балансын үнэтэй 1 айлын орон сууцыг 110.1 сая төгрөгөөр үнэлсэн, Баянхонгор сумын Номгон ахлах



сургуулийн 1972 онд ашиглалтад орсон 937,0 сая төгрөгийн хичээлийн 1-р байрын барилга дахин үнэлгээгээр 10420.0 сая төгрөгөөр үнэлэгдсэн байгаа нь хөрөнгийн дахин үнэлгээнд хийсэн хяналт хангалтгүй, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл нь тухай бүр асуудал тавьж арга хэмжээ аваагүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Галуут сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 2016 онд ашиглалтад орсон 8.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий “Баргилтын хөндийн худаг”, 2011 онд ашиглалтад орсон 2.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий “Овооны булгийн эхийн хашаа” гэсэн хөрөнгүүд нь хулгайд алдсан гэх шалтгаанаар үрэгдэж үгүй болсон гэсэн тайлбарыг ЗДТГ-ын нярав өгсөн тул хуулийн байгууллагад шилжүүлж хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, Мөн 2013 онд ашиглалтад орсон 15.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий “Хонгор хайрхан”-ы худгийн барилгыг ус гарахаа байсан гэх шалтгаанаар холбогдох шийдвэргүйгээр нураасан байгааг дахин засварлах албан шаардлагыг сумын ЗДТГ-т хүргүүлэв..
- Өлзийт сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 1970 онд ашиглалтад орсон 6.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий “Таацын гүүр” нь нурж устсан байхад холбогдох шийдвэрийг гаргуулж хөрөнгөөс хасаагүй байгаа тул холбогдох газарт хандаж шийдвэр гаргуулах албан шаардлагыг сумын ЗДТГ-т хүргүүлэв.
- Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгийн хөрөнгөнд бүртгэлтэй 38388.4 мянган төгрөгийн балансын үнэ бүхий тоглоомын талбайг холбогдох шийдвэргүйгээр Дэлхийн-Зөн ОУБ-д шилжүүлсэн байгаа тул холбогдох байгууллагад хандаж шийдвэр гаргуулах албан шаардлагыг аймгийн Нэгдсэн эмнэлэгийн даргад хүргүүлэв.

2.2 Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын тайланд тусгагдсан барилга байгууламжууд нь төрийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүрэн бүртгэгдсэн ч хөрөнгүүдийг нэр төрлөөр “Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн систем”-д бүрэн оруулаагүй байна.

2.2.1. Орон нутгийн өмчийн хөрөнгүүд нь төрийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүрэн бүртгэгдсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламжууд ТБОНӨТХ-ийн 78 дугаар зүйлийн 78.2.4¹⁸-д заасны дагуу Төрийн өмчийн нэгдсэн бүртгэлд 2017 оны жилийн эцсийн байдлаар 183830.3 сая төгрөгийн барилга байгууламж бүртгэгдсэн байна.

¹⁸ ТБОНӨТХ-ийн 78.2.4-т аймгийн Засаг дарга нь " орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах;"

2.2.2. Төрийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн орон нутгийн өмчийн барилга байгууламжийг “Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн систем”-д бүрэн оруулаагүй байна.

БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем” төсөл хэрэгжсэнээр “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д нэвтэрч байгууллагуудын орон нутгийн өмчийн барилга байгууламжийг нэр төрлөөр нь тус цахим системд 2014 оноос бүртгэн оруулж байна.

Тус ажлын явцад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хяналт шалгалт хийхэд 2017 оны жилийн эцсийн байдлаар 50.7 хувь, 2018 оны 3 дугаар сарын байдлаар 87.7%-ийн хэрэгжилттэй байгаа тул хөрөнгийн мэдээллийг системд бүрэн оруулах зөвлөмжийг ОНӨГ-т хүргүүлэв.

2.3 Орон нутгийн өмчийн газар нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй байна.

2.3.1 ОНӨГ нь 2014-2017 онуудад орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хадгалалт хамгаалалтын байдлыг хянан шалгах, түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.3.1.1. ИТХ нь ТБОНӨТХ-ийн 77 дугаар зүйлийн 77.2.1¹⁹-т заасан бүрэн эрхийн хэмжээнд аймгийн ИТХ нь орон нутгийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд дараах хяналт шалгалтуудыг зохион байгуулсан ч дээрх хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.2²⁰-т заасны дагуу ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргаас өмч хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөөгүй байна.

Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд Аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, ажлын албаны мэргэжилтэн оролцсон ажлын хэсэг Бөмбөгөр, Бууцагаан, Баацагаан, Баянговь, Баянлиг сумуудад ажиллаж төсөвт байгууллагад ашиглагдахгүй байгаа, МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт гарсан барилга байгууламжуудыг газар дээр нь үзэж танилцаж Баянговь сумын 160 хүүхдийн хичээлийн байрыг актлаж буулгах шийдвэр гарган газрыг чөлөөлсөн, мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар тогтоол гарган Бууцагаан, Баянлиг

¹⁹ ТБОНӨ-ийн тухай хуулийн 77.2.1-т "орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;

²⁰ ТБОНӨ-ийн тухай хуулийн 77.2.2-т " иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх"

сумдын төсөвт байгууллагуудад ашиглаж байсан хуучин барилгуудыг худалдах дуудлага худалдааны доод үнийг 20%-иар бууруулсан байна.

Мөн 2015 оны 05 дугаар сард аймгийн ИТХ-ын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын сэргээгдэх эрчим хүчний ашиглалтын талаар газар дээр очиж танилцаж хэрэгцээтэй газар нь шилжүүлэх асуудлыг судалсан гэх боловч сумдын удирдлагууд өөрийн сумдын багийн төвүүдэд ашиглах хүсэлт гаргасан тул асуудлыг бүрэн шийдвэрлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын ЗДТГ-ын хөрөнгөнд тус сумдад байгуулсан “Сэргээгдэх эрчим хүч”-ний байгууламжийг хөрөнгийн бүртгэлд хөрөнгө тус бүрийн үнийн задаргаа гаргаагүй нийт дүнгээр нь 920.0 сая төгрөгөөр тус тус бүртгэсэн байна. Тус сэргээгдэх эрчим хүчний байгууламжийг улсын комисс хүлээж аваагүй, хөрөнгийг үнийн задаргаа гарган үнэлж бүртгээгүй нийт дүнгээр нь 3 сумдад адилхан үнээр балансад бүртгэсэн ч Баянцагаан сумд 360ш нарны толь бүхий байгууламж, Баян-Өндөр, Шинэжинст сумдад 180ш нарны толь бүхий байгууламж баригдсан гэх мэтээр сумдын хөрөнгүүд нь харилцан адилгүй байна. Аудитын явцад хөрөнгийг газар дээр нь шалгаж холбогдох ажилтнуудаас тайлбар тодруулга авахад:

***Баянцагаан** сумын сэргээгдэх эрчим хүчний байгууламж нь 330ш нарны зайн толь, аккумулятор, 12 ш салхин сэнс, 2 контейнер түүн доторх тоног төхөөрөмж байснаас сэнснүүд бүгд эвдэрсэн, 180ш толь сумын төв дээр анх суурилагдснаараа, бусад контейнер доторх тоног төхөөрөмж ашиглалтгүй, харин 144 ш толь, аккумулятор нь 3 багийн төв болон 6 гүн өрмийн худаг дээр ашиглаж байна.*

***Баян-Өндөр** сумын эрчим хүчний байгууламж нь 180ш нарны зайн толь, аккумулятор, 12 ш салхин сэнс, 2 контейнер түүн доторх тоног төхөөрөмж байснаас сэнснүүд бүгд эвдэрсэн, контейнер доторх тоног төхөөрөмж ашиглалтгүй, толийг Амарбуяантын хийдийн багийн суурилуулан ашиглаж байгаа гэсэн тайлбарыг өгсөн.*

***Шинэжинст** сумын сумын эрчим хүчний байгууламж нь 180ш нарны зайн толь, аккумулятор, 12 ш салхин сэнс, 2 контейнер түүн доторх тоног төхөөрөмж байснаас сэнснүүд бүгд эвдэрсэн, Цагаан богдын заставт толь-30ш, аккумулятор-50ш, автомат шийт-1ш, Эхийн голд толь-88ш, аккумулятор-150ш, шийт 1ш-ийг тус тус ашиглуулж байгаа ба сумын ЗДТГ-т 60ш толь, контейнер 2ш болон бусад тоног төхөөрөмж ашиглалтгүй байна.*

Дээрх сэргээгдэх эрчим хүчний байгууламжуудын хөрөнгөөс зарим хэсэг нь ашиглалтгүй болсон, эвдэрсэн анх хөрөнгийг бүртгэхдээ нэр төрлөөр нь үнэлж бүртгээгүйгээс эвдэрсэн хөрөнгүүд данс бүртгэлээс хасагдаагүй байгаа тул холбогдох мэргэжлийн байгууллагад хандаж хөрөнгийг зөв үнэлж бүртгэн, ашиглагдахгүй байгаа хөрөнгийг хэрэгцээтэй газарт нь шилжүүлж ашиглалтыг сайжруулах зөвлөмжийг ОНӨГ-т хүргүүлэв.

2.3.1.2. Орон нутгийн өмчийн газар нь байгууллагуудын хөрөнгийг нэр төрлөөр нь нэгдсэн бүртгэлээр нэгтгэж хяналт тавьж байгаа боловч зарим хөрөнгүүд нь давхардаж бүртгэгдсэн, зарим сумдын ЭМТ-ийн эмчийн орон сууцыг иргэний өмчлөл, эзэмшлийн газар дээр барьснаас газрын гэрчилгээ солигдоогүй, байгууллагын эзэмшлийн газар дээр хувийн өмчийн барилга баригдсан байхад зохих арга хэмжээг аваагүй зөрчлүүд илэрч, 162.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг холбогдох байгууллагын дарга нарт хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн Цагдаагийн газрын хөрөнгөнд бүртгэлтэй 2007 онд ашиглалтад орсон 13.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий Заг, Гурванбулаг суманд орших 2 Цагдаагийн кабоны барилгууд нь тус сумдын ЗДТГ-ын хөрөнгөнд давхар бүртгэлтэй байгаа ба сумд дээрх барилгуудад засвар хийж, Заг сум зочид буудал, Гурванбулаг сум ахуйн үйлчилгээний зориулалтаар ашиглаж байгаа тул Цагдаагийн газрын данснаас хасах.
- Эрдэнэцогт сумын ЭМТ-ийн хөрөнгөнд бүртгэлтэй 1982 онд ашиглалтад орсон 31.6 сая төгрөгийн өртөгтэй эмийн сангийн барилгын үнэ дээр 2017 онд бүртгэлд байсан газрын үнэ 25.0 сая төгрөгийг нэмэгдүүлэн 56.6 сая төгрөгөөр бүртгэсэн, энэ хөрөнгө нь сумын ЭЭС-ийн хөрөнгөнд давхар бүртгэлтэй байгаа тул залруулж бүртгэх.
- Галуут сумын их эмчийн орон сууцны барилгын газрын гэрчилгээ нь иргэн Л.Батсүрэнгийн эзэмшилд, Баян-Овоо сумын их эмчийн орон сууц, ажилтны орон сууцны барилгын газрын гэрчилгээ нь иргэн Д.Энэбиш, Гиймаажав нарын өмчлөлд, Өлзийт сумын их эмчийн орон сууцны барилгын газрын гэрчилгээ нь иргэн Оюуны өмчлөлд бүртгэлтэй байгаа тул дээрх 92.7 сая төгрөгийн 4 барилгын газар эзэмших эрхийг байгууллагын нэр дээр гаргуулж авах.
- Өлзийт сумын ЕБС-ийн эзэмшилд бүртгэлтэй аж ахуйн хашаанд иргэн Г.Болд 2 жилийн өмнө хувийн орон сууцны байшин барьсан байгаа тул холбогдох газарт хандаж хуулийн дагуу шийдвэр гаргуулах.

2.3.1.3. Орон нутгийн өмчид Төрийн банкны хуучин барилга нь шилжиж ирээгүй байхад орон нутгийн төсвөөс 29.5 сая төгрөгийн засвар, 9.5 сая төгрөгийн гадна автозогсоол хийж 5-р цэцэрлэгийн хөрөнгөнд их засвараар 39.0 сая төгрөгөөр бүртгэсэн байна. Гэрээний 2.1-т 2016 оны 03 дугаар сараас эхлэн талуудын хооронд ашиглаж буй эд хөрөнгө балансаас шилжүүлэх хүртэл хугацаанд түрээсийн төлбөрт сард 1.2 сая төлөхөөр тусгасан байгаа ба дээрх түрээсийн зардлыг тухайн байгууллагын төсөвт тусгаагүй байна. Иймд хөрөнгийг шилжүүлэх асуудлыг холбогдох газарт дахин тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.3.1.4. Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан зарим цэцэрлэгийн барилгуудад ашиглалтын явцад чанарын болон стандартын шаардлага хангаагүйгээс мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарч дахин өргөтгөл, шинэчлэл хийх шаардлага үүсч байгаа тул цаашид төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалт, барилга угсралтын ажлын явцад мэргэжлийн байгууллагын тавих хяналт, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн барилга нь 2014 онд ашиглалтад орсон ч барилгын агааржуулалт салхивчийн систем ажиллахгүйгээс өвөлдөө цан цохиж хүйтэн байдаг ба барилгын бүх өрөө мөөгөнцөртсөн, зарим өрөө тасалгаа нь стандартад нийцэхгүй байна гэсэн МХГ-ын дүгнэлт гарсан, 9-р цэцэрлэг нь 2011 онд ашиглалтад орсон ч барилгын эргэн тойрны бетонон хаяавч хананаас хөндийрч барилгын суурь руу хурын ус орох нөхцөл бүрдсэн, цонхны ашиглалтын хугацаа дууссан, гал тогооны өрөө зарим ангийн агааржуулалт ажиллахгүй байгаа зэргээс аймгийн МХГ-ын улсын байцаагчийн 2018.03.20-ны өдрийн 05-07-003/28 тоот

дүгнэлтээр өргөтгөн шинэчлэх шаардлагатай гэж дүгнэсэн байгаа тул ОНӨГ, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ чанаргүй ажил гүйцэтгэсэн гүйцэтгэгч нартай хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн хичээлийн 2-р байранд 2015 онд “Халзан хайрхан” ХХК 155.3 сая төгрөгийн их засварын ажил хийснээс зарим ажлууд чанаргүй хийгдэж энэ талаар тус сургууль 2016.02.04-ий 18 тоот албан бичгээр зөрчил арилгуулах тухай хүсэлтээ гүйцэтгэгчид хүргүүлсэн боловч одоог хүртэл засвар хийгээгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 14.7²¹-дэх заалтыг зөрчиж байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.3.1.5. Сумдын төсөвт байгууллагууд төвлөрсөн халаалтад холбогдсонтой холбоотойгоор байгууллагуудын хөрөнгөнд бүртгэлтэй нам даралтын уурын зуухны барилга байгууламж, тоног төхөөрөмжийн холболтыг салгасан цаашид ашиглахгүй боломжгүй болсон байна. Иймд дээрх ашиглалтгүй болсон хөрөнгүүдийг хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах, холбогдох арга хэмжээ авах зөвлөмжийг холбогдох байгууллагын дарга нарт хүргүүлэв.

2.3.1.6. Баянлиг, Бууцагаан сумдад “Шинэ сум” төсөл хэрэгжиж төсөвт байгууллагуудын нэгдсэн халаалтын зуухыг сумын ИТХ-ын шийдвэрээр ААН-үүдэд түрээсээр ашиглуулж байгаа ч халаалтын уурын зуух, шугам сүлжээний түрээсийн төлбөрийг сард Баянлиг сум 0.6 сая, Бууцагаан сум 0.7 сая төгрөг авахаар гэрээ байгуулсан байна. Энэ нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 19 дүгээр батлагдсан “Орон нутгийн өмчийн барилгын, байгууламж болон үндсэн хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх журам”-ын 2.9²²-д заасны дагуу барилга байгууламж, объектийг цогцолбороор нь түрээслэх гэрээг аймгийн Засаг даргын зөвшөөрөл авч аймгийн ОНӨГ байгуулаагүйгээс аймгийн ОНӨГ нь гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй байна. Цаашид гэрээг ОНӨГ байгуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, аймгийн Тэргүүлэгчдээр дээрх тусгай зориулалтын цогцолбор объектийн барилга байгууламж, шугам сүлжээний түрээсийн төлбөрийн доод үнийг тогтоолгох зөвлөмжийг аймгийн ИТХ-ын даргад хүргүүлэв.

2.3.1.7. Баянговь, Баянлиг сумдын ЗДТГ-ын хөрөнгөнд 240.1 сая төгрөгөөр бүртгэлтэй Лигийн голын услалтын систем, 287.5 сая төгрөгөөр бүртгэлтэй Цагаан голын услалтын системүүдийн ашиглалтыг аудитын явцад газар дээр нь очиж шалгахад Баянлиг сумын услалтын систем нь ашиглалт хэвийн, Баянговь сумын Цагаан голын услалтын системийн хоёр далан нь 2016.06.11-д орсон хүчтэй борооны улмаас үерт автаж сэтэрснээс услалтын систем ашиглалтгүй болсон

²¹ Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна.

²² Төсөл сонгон шалгаруулсны үндсэн дээр түрээслэх барилга байгууламж, объектийн түрээслэх гэрээг аймгийн Засаг даргын зөвшөөрснөөр ОНӨАлба байгуулна.

талаар ажлын хэсэг гарч аймгийн Онцгой байдлын газарт 204 тоот, Хүнс, хөдөө аж ахуйн газарт 203 тоот албан бичгээр сумын Засаг дарга хандсан, мөн тус услалтын системийг барьж байгуулах явцад гүйцэтгэгч “Шимт газар” ХХК-д 2015.04.13-ны өдрийн 91 тоот, аймгийн ХХААГ-т 92 тоот албан бичгээр “2014 онд хийсэн гүйцэтгэгч компаний хийсэн услалтын систем толгойн барилгын ажлыг Цагаан голын урсдаг голидрол дотор хийсэн учир хуримтлагдаж хөлдсөн ус нь гэсэж хийсэн далангаа сэтэлж эвдэрсэн ус тогтоох далан хийсэн сав нь усаа барахгүй нэвт шүүрч чанар муутай хийгдсэн байна. иймд голын голидролоос нь гаргаж чанартай хийх тал дээр анхаарах” тухай хүргүүлсэн боловч арга хэмжээ аваагүй байгаа нь шат шатандаа тус асуудалд хариуцлагагүй хандсанаас төсвийн хөрөнгийн үр ашиг гараагүй байна. Цаашид тус асуудлыг мэргэжлийн байгууллагаар шалгуулан холбогдох газар тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.



2.3.1.8. Баянговь сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 199.8 сая “Цагаан голын гүүр”-ний ажлыг 2014-2015 онд “Баянтээх” ХХК ОНХС-ийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж гүйцэтгэж 2015.07.07-д “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссын акт”-аар хүлээлгэж өгсөн байна.

Баянговь сумын Засаг дарга 2018.03.09-ний 32 тоот албан бичгээр гүйцэтгэгчид компанид “гүүрний орчимд далангийн байгуулалтад нуралт үүссэн, нягтруулсан шороон далан нурж нарийссан, зорчих хэсэгт саад болохуйц эвдрэл бий болсон тул гэрээнд заагдсан 3 жилийн баталгаат хугацаатай учир гүүрний засварыг хийж өгөх”-ийг уламжилсан байна. Аудитаар газар дээр нь очиж гүүрний ашиглалтыг шалгахад дээрх албан бичигт тусгасан зөрчлөөс гадна гүүрний төмөр бетон дундуураа гулзайлт үүсч хотойсноос гүүрэнд ан цав үүссэн байдалтай байгаа тул мэргэжлийн байгууллагаар шалгуулж баталгаат хугацаанд засварыг хийлгэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.



2.3.2. 2016 онд ОНӨ-ийн барилга байгууламжийн нэгдсэн тооллого явуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан байна.

ТБОНӨТХ-ийн 70 дугаар зүйлд заасны дагуу ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2016 оны 36 дугаар тогтоолоор “Эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах тухай” шийдвэр гарч, аймгийн Засаг даргын 2016 оны а/274 тоот захирамжаар тооллогын комиссыг томилсон байна. Мөн ИТХ-аас 2016 оны 05 сарын 02-ы өдөр боловсруулж баталсан орон нутгийн өмчит төсөвт байгууллагуудын хөрөнгийн тооллого хийх, хөрөнгийн эмх цэгц, өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын үр дүн, албан байгууллагуудын дотоодын тооллого хийсэн байдалд хяналт тавих удирдамжийн дагуу ажлын хэсэг ажиллаж дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2016 оны 110 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн илэрсэн зөрчлийн талаар авах арга хэмжээний тухай шийдвэр гаргуулсан байна. Дээрх тогтоолоор аймгийн Засаг дарга газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг улсын бүртгэлд бүртгүүлээгүй, барилга байгууламжийн газрын гэрчилгээгүй зөрчлийг арилгах, хандив тусламжаар ирсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаж байхыг үүрэг болгосон байхад хэрэгжээгүй, аудитаар дээрх зөрчил давтан гарч байна.

Аудитаар түүвэрт хамрагдсан сумдын Засаг дарга нар нь ТБОНӨТХ-ийн 78 дугаар зүйлийн 78.2.4-д заасны дагуу эд хөрөнгийн тооллого явуулах шийдвэрийг захирамжаар гаргаж явуулж байгаа ч үр дүнг хэлэлцэж шаардлагатай арга хэмжээ аваагүй байна.

Иймд тооллогын үр дүнг хэлэлцэж, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, дахин үнэлгээнд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг ОНӨГ-т хүргүүлэв.

Аудитаар нийт 8695.6 сая төгрөгийн зөрчил илэрч, 4091.5 сая төгрөгийн албан шаардлага, 379.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4224.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг хүргүүлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нийцлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Аудитын түүвэрт хамрагдсан төсөвт байгууллагуудаас 2014-2017 онд төсвийн хөрөнгөөр болон хандив, тусламжийн эх үүсвэрээр бэлтгэгдсэн 362.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, 27 байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй 3322.5 сая төгрөгийн барилга, байгууламж ашиглалтгүй байна.

2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу орон нутгийн өмчийг төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудад эзэмшүүлэх гэрээг байгуулаагүй, байгууллагууд өөрийн хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламжийн хувийн хэргийг бүрэн хөтөлж баяжилт хийгээгүй байна.

3. Орон нутгийн өмчийн зарим барилга байгууламжийг бусдад эзэмшүүлж ашиглуулахдаа түрээсийн гэрээ байгуулаагүй, түрээсийн гэрээгээр ашиглуулж байгаа объектийн түрээсийн төлбөрийн 4,4 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

4. Эрдэнэцогт, Бууцагаан сумын ЭМТ-ийн ашиглалтгүй барилга, Шаргалжуут тосгоны цэцэрлэгийн хуучин барилгыг сумдын Засаг дарга нар өөрийн эзэмшилд шилжээгүй байхад сумдад ахуйн үйлчилгээний зориулалтаар иргэдэд ашиглуулж байгаа ч Эрдэнэцогт сум барилгын халаалтын зардлыг ЭМТ-ийн төсвөөс төлж байна.

5. Засгийн газрын 1998 оны 148 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн улс төрийн болон төрийн тусгай албыг тодорхой хугацаагаар хашихаар томилогдсон төрийн мэдлийн орон сууцанд суух албан тушаалтнуудын жагсаалт”-д тусгагдсанаас гадна 2 орон сууц илүү байгааг Цагдаагийн газрын дэд дарга, ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн ажилтанд эзэмшүүлж байна.

6. Орон нутгийн өмчийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлага худалдаагаар худалдах, актлахдаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөөгүйгээс 121.6 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаагүй, актлах шийдвэр гараагүй 492,9 сая төгрөгийн өртөг бүхий 3 барилгыг буулгасан байна.

7. Баянлиг сумын сургуулийн дотуур байрыг 51,9 сая төгрөгөөр дуудлага худалдаагаар худалдсан ч төлбөрийн үлдэгдэл 41.5 сая төгрөгийг төлөөгүй атлаа худалдан авагч иргэн барилгыг орон сууцны зориулалтаар засвар, шинэчлэл

хийсэн ба тухайн иргэн уг барилгаас 3 сууцыг дээрх төлбөрт тооцож төсөвт байгууллагад өгсөн нь ТБОНӨТухай хуулийн 63.3 дахь заалтыг зөрчсөн байна.

8. Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хадгалалт хамгаалалтын байдал, түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах ажлыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс барилга байгууламжийг материалын нэрээр, бусад хөрөнгийн дансанд болон давхар бүртгэсэн, бусдын эзэмшил болон өмчлөлийн газар дээр байгуулсан барилгын газрын гэрчилгээг шилжүүлээгүй байна.

9. Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын ЗДТГ-ын хөрөнгөнд сэргээгдэх эрчим хүчний байгууламжуудыг анх 920.0 сая төгрөгөөр бүртгэхдээ хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан үнэлж бүртгээгүйгээс ашиглалтгүй болсон хэсгийг данснаас хасах бололцоогүй, үрэгдсэн, алга болсон хөрөнгийг үнэлэх, тоолох боломжгүй болсон байна.

10. Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан барилга байгууламж болон их засварын ажлууд нь ашиглалтын явцад чанарын болон стандартын шаардлага хангаагүйгээс эвдрэл гэмтэл үүссэнийг тухай бүр гүйцэтгэгч байгууллагуудад дахин засварлуулах шаардлагыг хүргүүлсэн боловч засвар хийгдээгүй байна.

11. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын тайланд тусгагдсан барилга байгууламжуудыг "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-ийн цахим бүртгэлд бүрэн оруулаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2018.06.26

Баянхонгор хот

Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд хийсэн нийцлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорхи албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Нэг. Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа

1. Аймгийн ИТХ нь орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахдаа ТБОНӨ-ийн тухай хуулийн 77.2.2-т “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх” заасан эрхээ хэрэгжүүлж ажиллах.

2. Баянлиг, Бууцагаан сумын төсвийн хөрөнгөөр баригдсан халаалтын уурын зуухны барилга, шугам сүлжээний цогцолбор объектийг түрээслэх түрээсийн төлбөрийн доод үнийг тогтоох.

Хоёр. Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа

1. Сумдад УТХО-р бий болсон услалтын системүүдийн ашиглалт хадгалалт хамгаалалтын байдалд тавих хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг аймгийн ИТХ-р хэлэлцүүлж, хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх.

2. Цагдаагийн газрын дэд дарга, ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн албаны ажилтан нарын амьдарч байгаа орон сууцнууд нь Засгийн газрын 1998 оны 148 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан албан тушаалтны жагсаалтад ороогүй тул холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авах.

3. Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн Төрийн банкны хуучин барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэх асуудлыг холбогдох газарт дахин тавьж шийдвэрлүүлэх.

4. ТБОНӨ-ийн тухай хуулийг зөрчин дуудлага худалдаагаар худалдсан барилга байгууламжийн орлогыг хугацаанд нь төвлөрүүлээгүй бол хууль, журмын дагуу хүчингүй болгож байх, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцох.

5. Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан 9, 12 дугаар цэцэрлэгийн барилгууд, Баянговь сумын Цагаан голын услалтын систем, Цагаан голын гүүрний ажлын гүйцэтгэгч байгууллагуудад хариуцлага тооцож ажиллах.

6. Номгон ахлах сургуулийн хичээлийн 2 дугаар байрны засварын зарим ажил нь ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй байгаа тул гүйцэтгэгч байгууллагаар дахин засварлуулах.

Гурав. ОНӨГ-ын дарга Ц.Идэрмөнх танаа

1. Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын сэргээгдэх эрчим хүчний байгууламжуудын хөрөнгөөс зарим хэсэг нь ашиглалтгүй болсон, эвдэрсэн анх хөрөнгийг бүртгэхдээ нэр төрлөөр нь үнэлж бүртгээгүйгээс эвдэрсэн хөрөнгүүд данс бүртгэлээс хасагдаагүй байгаа тул холбогдох мэргэжлийн байгууллагад хандаж хөрөнгийг зөв үнэлж бүртгэн, ашиглагдахгүй байгаа хөрөнгийг хэрэгцээтэй газарт нь шилжүүлж ашиглалтыг сайжруулах.

2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлага худалдаагаар худалдах, актлахдаа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж, дуудлага худалдааны орлогыг хуульд заасан нөхцөлөөр бүрэн төвлөрүүлж ажиллах.

3. Төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудтай орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээг байгуулж, байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийг мэргэжил арга зүйгээр хангаж, тооллогын үр дүнг хэлэлцэж, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, дахин үнэлгээнд тавих хяналтыг сайжруулах.

4. “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д орон нутгийн өмчийн барилга байгууламжуудыг бүрэн оруулах.

Дөрөв. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Байгалмаа танаа

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр орон сууц худалдан авахдаа Засгийн газрын 1998 оны 148 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн улс төрийн болон төрийн тусгай албыг тодорхой хугацаагаар хашиж буй албан тушаалтнуудын жагсаалт”-ыг мөрдөж төрийн мэдлийн орон сууцыг худалдан авах шийдвэр гаргуулахдаа хуучин орон сууцыг худалдах асуудлыг хамтад нь шийдвэрлүүлж төсвийн үргүй зардал гаргахгүй байх.

Тав. Сумдын Засаг дарга, байгууллагын дарга нарт

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламжуудын хувийн хэргийг Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2-д заасны дагуу нээж баяжилтийг тухай бүр хийж, барилга байгууламжуудын газрын гэрчилгээг бүрэн гаргуулж улсын бүртгэлд бүртгүүлэх.

2. Түүвэрт хамрагдсан төсөвт 27 байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй 3322.5 сая төгрөгийн ашиглалтгүй барилга байгууламж, Бууцагаан сумын Соёлын төв, Бага сургууль, Баян-Овоо сумын Спорт заалны дуусаагүй барилга, байгууллагуудын нам даралтын уурын зуухны байгууламжуудыг холбогдох хуулийн дагуу цаашид хэрхэн ашиглах саналаа аймгийн ИТХ-д тавьж тодорхой шийдвэр гаргуулж ажиллах.

3. Төсөвт байгууллагууд өөрийн хөрөнгийг бусдад ашиглуулахдаа аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан журмын дагуу гэрээ байгуулж орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх.

4. Эрдэнэцогт, Бууцагаан сумын ЭМТ-ийн ашиглалтгүй барилга, Шаргалжуут тосгоны цэцэрлэгийн хуучин барилгыг сумдын Засаг дарга өөрийн эзэмшилд шилжээгүй байхад бусдад ашиглуулж байгаа тул хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

5. Эрдэнэцогт сумын ЭМТ-ийн бусдад ахуйн үйлчилгээний зориулалтаар ашиглуулж байгаа аж ахуйн хэсгийн складын барилгын халаалтын зардлыг ЭМТ-ийн төсвөөс төлж байгааг зогсоох.

6. ХХААГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бууцагаан суманд байгуулсан нядалгааны цехийн тоног төхөөрөмжийг хэрэгцээтэй газар нь шилжүүлж ашиглалтыг сайжруулах.

7. Галуут сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 21.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий "Ахуйн үйлчилгээний барилга"-ын талаарх маргаантай асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2018 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ